



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар A/208

Улаанбаатар хот

“JALT 2025” чуулга уулзалтад
оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хууль 31 дүгээр зүйлийн 31.1.6, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлах тухай” А/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсад 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулагдах Олон Улсын англи хэлний багш, мэргэжилтэн судлаач, оюутнуудад зориулсан “JALT 2025” чуулга уулзалтад 94 дүгээр сургуулийн англи хэлний багш Баярсайханы Баярмааг оролцуулсугай.

2. Арга хэмжээнд оролцоход шаардагдах төсвийг хавсралтаар баталж, зарцуулагдах 1.777,450 (нэг сая долоон зуун далан долоон мянга дөрвөн зуун тавь) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 08 ны өдрийн
А/Б.О.Б дугаар захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Тийзний үнэ	ш	1,777.449	1	1,777.450
	Нийт дүн				1,777.450